



ЧЕХ УЛС ДАХЬ
МОНГОЛЧУУДЫН ХОЛБОО

БНЧУ-Д АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БУЙ МОНГОЛ ИРГЭДИЙН МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ХЭМЖЭЭГ ТООЦООЛОХ ТҮҮВЭР СУДАЛГАА¹

Хураангуй

Гадаад орнуудад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн эх орон руугаа илгээж байгаа мөнгөн гуйвуулгын хэмжээ жилээс жилд нэмэгдэн, улс орны эдийн засагт үнэтэй хувь нэмэр оруулсаар ирсэн билээ. Гэвч нөгөөтэйгүүр Монгол иргэдийн дийлэнх нь хувь хүнээр дамжуулан мөнгө илгээх буюу банкны системээс гадуур мөнгөн шилжүүлэг үйлддэгээс улбаалан энэ төрлийн статистик мэдээ дутмаг байсаар ирсэн. Иймд энэ үзүүлэлтийн статистикийн чанарыг сайжруулах зорилгоор Монголбанк нь Монгол иргэд олноор оршин суудаг улс орнуудад мөнгөн гуйвуулгын түүвэр судалгааг тогтмолжуулахаар ажиллаж байгаа бөгөөд эхний ээлжинд “Чех Улс дахь Монголчуудын Холбоо” ТББ-тай хамтран энэхүү түүвэр судалгааг гүйцэтгэлээ.

БНЧУ нь гадаадад оршин суугаа Монгол иргэдийн тоогоор 3 дугаарт ордог², тэдний 70 орчим хувь нь хувиараа болон хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад байдаг. Чехийн гадаад иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газрын бүртгэлээр тус улсад 2012 оны 11 дүгээр сарын байдлаар 5338 Монгол иргэн оршин сууж байгаагаас түүвэр судалгаанд 427 иргэн буюу 8%-ийг хамруулсан нь 95%-ийн итгэх түвшинд эх олонлогийг тайлбарлах чадвартай байна. Судалгаанд хамрагдагсдын **85%** нь тодорхой давтамжтайгаар эх орон руугаа мөнгө гуйвуулдаг бөгөөд 1 иргэний шилжүүлгийн дүн жилд дунджаар **2,041** ам.доллар байна. Үүний **50** орчим хувийг банкны системээс гадуур буюу гуйвуулгын бусад арга хэрэгслээр дамжуулан шилжүүлж байна. Түүврийн дүнг эх олонлогт тархааж тооцвол 2012 оны байдлаар цэвэр дүнгээр ойролцоогоор **4.6 сая** ам.доллартай тэнцэх хэмжээний гадаад валютыг эх орон руугаа шилжүүлсэн дүн гарлаа.


¹Т.Түвшингэрэл, ВЭЗГ-ын ТТССХ-ын эдийн засагч, 319532 [208], tuvshingerel@mongolbank.mn

²Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого, УСХ

I. Ерөнхий мэдээлэл

Зах зээлийн шилжилтийн үед гарсан нийгмийн томоохон өөрчлөлтүүдийн нэг бол хөдөлмөрийн насны иргэд гадаад орон руу олноор явж, ажиллах болсон үзэгдэл юм. Албан мэдээнээс үзвэл 2010 оны байдлаар 107 мянган иргэн буюу Монгол Улсын нийт хүн амын³ 3.7% нь гадаадад оршин сууж байгаа статистик үзүүлэлттэй байна. Гэвч Хил хамгаалах ерөнхий газрын судалгаанд үндэслэн 1990 оноос хойш Монгол иргэдийн улсын хилээр орж, гарсан тоон өгөгдлийн зөрүүгээр тооцвол өссөн дүнгээр 338 мянга гаруй иргэд гадаад улсад оршин сууж байгаа дүн гарч байна. Өөрөөр хэлбэл гадаадад амьдарч буй Монгол иргэдийн визний статус зэрэг тодорхой хүчин зүйлсээс шалтгаалан оршин суугчдын тоог нарийвчлан тодорхойлоход хүндрэлтэй байдаг бөгөөд бодит оршин суугчдын тоо нь албан тооноос 2-3 дахин өндөр байх магадлалтай байна. Ямартай ч ХХЕГ-ын мэдээнээс үзвэл сүүлийн жилүүдэд Монгол иргэдийн гадаадад суурьших өсөлт буурч байна гэж дүгнэж болохоор байна.

Дүрслэл 1: Хилээр орж, гарсан Монгол иргэдийн тоо




Эх сурвалж: ХХЕГ

Дүрслэл 2: Ажиллагсдын гуйвуулга, 2000-2012



Эх сурвалж: Төлбөрийн тэнцэл

Дүрслэл 3: Ажиллагсдын гуйвуулгын урсгал



Эх сурвалж: Гадаад гүйлгээний тайлан

Гадаадын улс орнуудад хөдөлмөр эрхэлж буй Монгол иргэдийн банкны системээр дамжуулан эх орон руугаа шилжүүлсэн хувийн гуйвуулгын хэмжээ сүүлийн 12 жилийн хугацаанд тогтвортой өссөн бөгөөд дотоодын эдийн засагт томоохон хувь нэмрийг оруулсаар иржээ. Оргил үе буюу 2004 онд ДНБ-ний 10%-тай тэнцэх хэмжээний гадаад валютын мөнгөн гуйвуулгыг гадаадад хөдөлмөр эрхэлж буй Монгол иргэдээс хүлээн авсан байна.

Сүүлийн жилүүдийн статистикаас үзвэл гадаадад хөдөлмөр эрхэлж буй Монгол иргэдийн Монгол руу шилжүүлэх хувийн гуйвуулгын дүнгийн өсөлт саарч, Монголд хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийн эх орон руугаа гуйвуулах гуйвуулгын хэмжээ хурдацтайгаар өсч, улмаар ажиллагсдын хувийн гуйвуулгын цэвэр орлого буурах хандлагатай байна. Энэ нь нэг талаар

³2012 оны жилийн эцсийн байдлаарх хүн амын тоо.

Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад иргэдийн тоо нэмэгдэж, гадаадад амьдарч буй Монгол иргэд нь тухайн улсад тогтвор суурьшилтай амьдрах сонирхолтой болсноос үүдэлтэй байж болох ч, нөгөө талаар гадаадад амьдарч буй Монгол иргэд нь албан бус шугамаар буюу банкны системээс гадуур гуйвуулга үйлдэх болсноос улбаалан статистик мэдээлэл нь дутуу бүртгэгдэж байх магадлалтай юм.

II. Судалгааны зорилго


Гадаадад ажиллаж буй Монгол иргэдийн эх орон руугаа шилжүүлж буй хувийн гуйвуулгын статистик мэдээг төлбөрийн тэнцэл дэх урсгал шилжүүлгийн дэд дансанд бүртгэдэг бөгөөд уг статистик мэдээний эх сурвалжаар Монголбанкнаас боловсруулдаг “Гадаад гүйлгээний тайлан”⁴-г ашигладаг билээ.

Хүн ам, орон сууцны улсын тооллогын 2010 оны дүнгээс үзэхэд БНЧУ нь гадаадад оршин суугаа Монгол иргэдийн тоогоор 3-т ордог бөгөөл тэдний 70 орчим хувь нь хувиараа болон хөдөлмөрийн гэрээгээр ажиллах зорилгоор явсан иргэд байна. Гэвч гадаад гүйлгээний тайлангаас үзэхэд БНЧУ-аас эх орон руугаа шилжүүлж буй хувийн гуйвуулгын хэмжээ нь сүүлийн 5 жилийн байдлаар нийт хувийн гуйвуулгын орох урсгалын 1%-аас хэтрэхгүй байна. Өөрөөр хэлбэл тус улсаас албан бус шугамаар буюу банкны системээс гадуур шилжүүлж буй гуйвуулгын хэмжээ өндөр байх магадлалтай тул хоёр улсын хооронд хийгдэж буй хувийн гуйвуулгын хэмжээг бодитоор тогтоон, төлбөрийн тэнцлийн статистикийг сайжруулах зорилгоор “БНЧУ-д ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн мөнгөн гуйвуулгын хэмжээг тооцоолох түүвэр судалгаа”-г зохион байгууллаа.

Хүснэгт 1: Төлбөрийн тэнцлийн хураангуй хүснэгт

I. Урсгал тэнцэл	
A. Бараа ба үйлчилгээний худалдаа	
B. Орлого	
C. Урсгал шилжүүлэг	
Үүнээс: Ажиллагсдын гуйвуулга	
Кредит	
Дебит	
II. Хөрөнгө ба санхүүгийн тэнцэл	
A. Хөрөнгийн данс	
B. Санхүүгийн данс	
III. Алдаа болон орхигдуулга	
IV. Гадаад валютын цэвэр нөөцийн өөрчлөлт	

Дүрслэл 4: БНЧУ-аас хийгдэж буй хувийн гуйвуулга



Эх сурвалж: Гадаад гүйлгээний тайлан

Түүнчлэн БНЧУ-д оршин сууж буй иргэдийн талаарх бодит мэдээллийг тусгах зорилгоор тус улсад ажиллаж, амьдарч буй иргэдээс мэдээлэл аван, холбогдох хэсгүүдэд нэмэлт тайлбар хэлбэрээр оруулсан болно.


⁴ Арилжааны банкуудаар дамжин хийгдэж байгаа манай улсын “эдийн засгийн харъяат” болон “эдийн засгийн харъяат бус” хоорондын гадаад төлбөр тооцооны дүн нэгтгэлийг хэлнэ. 2012 оны эцсийн байдлаар 13 арилжааны банк болон 2 ББСБ-аас сарын мэдээг аван нэгтгэж байна.

III. Судалгааны аргазүй, түүвэр


Судалгааны анкетийг цахим хуудсанд байршуулан⁵, судалгаа авах хүсэлтийг “Чех Улс дахь Монголчуудын Холбоо” ТББ-аар дамжуулан тус улсад оршин сууж байгаа Монгол иргэд олноор зочилдог цахим хуудсуудад⁶ байршуулах, “Моннет” үүрэн холбооны сүлжээний идэвхтэй хэрэглэгчид рүү мессэж болон и-мэйл сурталчилгаа явуулах зэрэг цахим хэлбэрээр түгээж, цаасан эхийг Монгол иргэдийн гэрийн хаяг руу шуудангаар хүргүүлэх замаар нийт 427 иргэдийг санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгон хамрууллаа.

Чехийн гадаад иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газрын бүртгэлээр⁷ тус улсад 2012 оны 11 дүгээр сарын байдлаар 5338 Монгол иргэн оршин сууж байна. Иймд судалгааны түүвэр нь эх олонлогийн 8%-ийг хамарч, 95%-ийн итгэх түвшинд эх олонлогийг тайлбарлах чадвартай байна.

Дүрслэл 5: Нас, хүйсний бүтэц




Дүрслэл 6: Боловсролын түвшин



Судалгаанд хамрагдсан иргэдийн 63%-ийг эмэгтэйчүүд, 60%-ийг 30-45 насны иргэд эзэлж байна. Энэ нь 2000 оноос эхлэн тус улсад хөдөлмөрийн гэрээгээр оёдлын үйлдвэрт ажиллах зорилгоор 20-40 насны эмэгтэйчүүд олноор явж, суурьшсантай холбоотой байна⁸.

Боловсролын түвшингийн хувьд бакалавраас дээш боловсролын зэрэгтэй иргэд нийт түүврийн 35 хувийг эзэлж байна.

Дүрслэл 7: Оршин сууж буй зорилго



Хүснэгт 2: Оршин сууж буй хугацаа, зорилгоор

Т Зорилго	0-1 жил	1-3 жил	3-5 жил	5-аас дээш
Ажиллах	1%	3%	24%	72%
Суралцах	9%	36%	27%	27%
Тогтвортой амьдрах	0%	2%	18%	79%
Нийт	1%	4%	23%	72%

Оршин сууж буй зорилгоор авч үзвэл судалгаанд оролцогчдын дийлэнх нь ажиллах зорилгоор тус улсад амьдарч байна. Оршин сууж байгаа иргэдийн 95% нь 3-аас дээш жил тухайн оронд амьдарч байгаа дүн гарсан бөгөөд сүүлийн жилүүдэд ажиллах зорилгоор тус орныг зорих иргэдийн тоо буурсан хандлагатай байна. Харин амьдарсан хугацаа нэмэгдэхийн хэрээр тогтвор суурьшилтай амьдрах хүсэлтэй болдог хандлагатай байна.

⁵Судалгааны маягтын холбоос: <http://tinyurl.com/cyuc4au>

⁶Дараах цахим хуудсуудад байршуулсан: <http://terguulegch.com/>; <http://monnet.cz/>; <http://www.zarlal.cz/>.

⁷Монгол Улсаас БНЧУ-д суугаа Элчин сайдын яамны мэдээлснээр

⁸“Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар” судалгааны тайлан, 2005, МХАХН.


“Энд ирэхдээ хүмүүс байр орноо зарж, өр тавьж ирдэг. Ажиллаж мөнгө олоод өрөө төлнө, орон байртай болно, Монголдоо ирээд тав тухтай амьдрах нөхцлөө бүрдүүлнэ гэсэн зорилготой ирдэг бол сүүлийн жилүүдэд Монгол дахь орон сууц, хашаа байшингийн үнийн өсөлт хэт өндөр болсноос тэр зорилгодоо хүрэхэд хүнд болсон. Энэ зорилго байхгүй учир өөр тодорхой хүрч болохуйц зорилготой болтлоо АЖИГЛАЛТЫН БАЙДАЛТАЙ байгаа. Түүнээс биш энд тогтвор суурьшилтай насаараа амьдарна гэсэн зорилготой хүн байхгүй гэж бодож байна.”

/Чехэд оршин суугч иргэн/


IV. Судалгааны нэгдсэн дүн⁹

Нийт судалгаанд оролцогчдын 50 орчим хувь нь сард дунджаар **500-750** ам.долларын цалинтай ажилладаг байна. Боловсролын түвшингээс хамааран орлогын хэмжээнд бага зэрэг өөрчлөлт ажиглагдсан ба хүйсийн хувьд эрэгтэй хүмүүсийн дундаж орлого нь эмэгтэйчүүдийхээс 50 орчим ам.доллараар өндөр байна.


Дүрслэл 8: Сарын дундаж орлого(ам.доллар)



Дүрслэл 9: Орлогоосоо хуримтлал үүсгэдэг үү?



Дүрслэл 10: Хуримтлал тань ойрын 1 жилийн хугацаанд өссөн үү?




Судалгаанд хамрагдагсдын тал нь орлогоосоо хуримтлал үүсгэдэг бөгөөд тэдний 80 орчим хувийх нь хуримтлал сүүлийн 1 жилийн хугацаанд өссөн үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл гадаадад ажиллаж хуримтлал үүсгэх, байрны мөнгө олох зорилгоор явсан Монгол иргэдийн маань хуримтлал үүсгэх идэвхи суларсан гэж дүгнэж болохоор байна.

“Хуримтлал үүсгэхгүй байгаа шалтгаан нь нөгөө л ар гэрийн байдалтай холбоотой. Монгол руу хүүхдийн сургалтын төлбөр шилжүүлэх, аав ээждээ хандив өргөх, зээлээ төлөх гэх мэт шалтгаанууд байдаг тул хуримтлал үүсгэхгүй байгаа.”

/Чехэд оршин суугч иргэн/

⁹Судалгааны нэгдсэн дүнг гаргахдаа судалгааны зорилгод нийцүүлэн зөвхөн “суралцах” зорилгоор оршин сууж буй иргэдийн түүврийг хасч боловсруулав.

Дүрслэл 11: Мөнгөн гуйвуулга хүлээн авдаг, шилжүүлдэг байдал



Хүснэгт 3: Шилжүүлдэг болон хүлээн авдаг давтамж, 1 удаагийн дундаж шилжүүлгийн хэмжээ (ам.доллар)

Давтамж	Шилжүүлдэг		Хүлээн авдаг	
	Жин	Дундаж	Жин	Дундаж
Жилд 1-2 удаа	22%	438	7%	414
Улиралд 1-2 удаа	37%	385	3%	721
Сард 1-2 удаа	20%	302	1%	830
Бусад	6%	338	1%	450
Хариулаагүй	1%	-	1%	500
Нийт	85%	404	13%	535

Судалгаанд оролцогчдын 13% нь огт шилжүүлэг хийдэггүй гэж хариулсан бол 11% нь мөнгө хүлээн авч, мөн шилжүүлдэг гэсэн хариултыг сонгожээ. Мөнгөн шилжүүлэг хийдэг иргэд нь бараа бүтээгдэхүүн Монгол руу явуулж заруулан, төлбөрийг буцаан авдаг бололтой байна. Судалгаагаар БНЧУ-д амьдарч буй иргэдийн 85% нь 1 удаад дунджаар 404 ам.долларыг эх орон руугаа илгээдэг дүн гарлаа. Шилжүүлэг хийдэг давтамжийн хувьд жилд 1-6 удаа шилжүүлэг хийдэг иргэд дийлэнх хувийг эзэлж байна.

“Ихэвчлэн эндээс машин, барилгын материал, наймааны бараа авч Монгол явуулахын тулд гэрээсээ мөнгө авдаг. Өөрөөр хэлбэл амьжиргаандаа зориулж гэрээсээ мөнгө авдаг гэсэн үг биш. Мөн өөр визэнд орох, өөр улс руу явж ажиллах, Монгол руу буцах гэх мэт маш олон жижиг шалтгаанууд байдаг.

/Чехэд оршин суугч иргэн/


Хүснэгт 4: Ажиллагсдын 1 сард хүлээн авч, шилжүүлж буй гуйвуулгын хэмжээ

Хэмжээ (ам.доллар)	Шилжүүлсэн	Хүлээн авсан
1-50	20%	4%
50-100	13%	3%
101-200	26%	1%
201-350	17%	0%
351-500	4%	0%
501-700	1%	1%
701-900	1%	0%
901-ээс дээш	1%	1%
Бараг үгүй	15%	87%
Тодорхойгүй	2%	1%

Мөнгөн гуйвуулгын хэмжээг нарийвчилбал нийт түүвэрт хамрагдагсдын 85% нь 1 сард дунджаар 170 ам.доллар эх орон руугаа гуйвуулж, 13% нь сард дунджаар 256 ам.долларыг гэрээсээ хүлээн авдаг байна.


Судалгаанд хамрагдагсдын 50% нь ар гэрийнхээ хувийн хэрэгцээнд зориулан эх орон руугаа мөнгө гуйвуулдаг бол 20% нь зээл төлөх, 11% нь банкин хадгалуулах, 17% нь бизнесийн хөрөнгө оруулалт хийх, орон сууц худалдан авах зорилгоор мөнгө шилжүүлдэг байна.

Дүрслэл 12: Гуйвуулгын хэлбэр



Гуйвуулга хийх хэлбэрийн хувьд албан бус сувгаар буюу хувь хүнээр дамжуулан шилжүүлэг үйлддэг иргэд тал орчим хувийг эзэлж байна. Энэ хэлбэрийг сонгох нь шимтгэлийн хувьд хямт тусдаг тул өргөнөөр ашигладаг гэж хариулжээ. Түүнчлэн гадаад гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ-аар дамжуулан мөнгө шилжүүлэх нь элбэг байдаг байна.

Дүрслэл 13: Гуйвуулгын хэлбэрийг сонгосон шалтгаан



Дүрслэл 14: Гуйвуулгын үйлчилгээнд шаардлагатай зүйлс



Албан бус сувгаар мөнгө шилжүүлэх нь эрсдэл өндөртэй, цаг хугацааны хувьд алдагдалтай байдаг тул албан сувгаар үйлчлүүлэх хүсэлтэй иргэд олон байгаа боловч тэдэнд хандсан үйлчилгээ сул байдаг гэж хариулжээ.

Түүвэр судалгааны маягтад бусад санал хүсэлтийг нээлттэй хариулах хэлбэрээр оруулсан бөгөөд банкны салбарын талаар дараахсаналууд зонхилж байлаа.

1. БНЧУ-д Монголын ямар нэг арилжааны банкны салбартай болох,
2. Гуйвуулгын үйлчилгээний чанарыг сайжруулах,
3. Гадаадаас орон сууц худалдан авах боломж гаргаж өгөх,
4. Гуйвуулгыг шууд хадгаламжийн данс руу хийх боломж олгох.

V. Тооцоолол, нэмэлт шинжилгээ

Түүвэр судалгаагаар БНЧУ-д оршин сууж буй нэгж иргэний эх орон руугаа шилжүүлж, хүлээн авч байгаа гуйвуулгын жилийн дундаж дүнг тодорхойлсон бөгөөд энэ бүлэгт судалгаанд хамрагдагсад нь нийт БНЧУ-д оршин суугч иргэдийг бүрэн төлөөлж чадна гэсэн таамаглалд үндэслэн 1 жилд хоёр улсын хооронд хийгдэж буй ажиллагсдын мөнгөн гуйвуулгын нийт дүнг тооцон гаргалаа.

Хамгийн сүүлийн үеийн албан тоогоор¹⁰ БНЧУ-д нийт 5338 Монгол иргэн оршин сууж байгаа тоо байгаа нь бодит үзүүлэлтээс бага дүн байх магадлалтай ч ямар нэг тоо баримтгүй таамаглал дэвшүүлэхээс зайлсхийсэн тул тооцоололд энэ тоог ашиглалаа. Гадаадад оршин сууж буй иргэдийн 20% нь насанд хүрээгүй иргэд¹¹, 1% нь хөдөлмөрлөх боломжгүй өндөр настай иргэд байдаг гэж тооцон, үлдсэн хөдөлмөрийн чадвартай насны иргэдийн 80% нь ажиллах зорилгоор оршин сууж байгаа гэж үзвэл БНЧУ-д ойролцоогоор 3375 иргэн идэвхтэйгээр хөдөлмөр эрхэлж байна.

Хүснэгт 4: БНЧУ болон Монгол Улсын хооронд хийгдсэн мөнгөн гуйвуулгын тооцоо, 2012 он

	Нийт оршин суугчид	Хувийн жин	Иргэдийн тоо	Дундаж,(\$)	Нийт 1 жилд (сая \$)	Үүнээс		
						Албан	Албан бус	ББСБ
	a	b	c=a*b	d	e=c*d			
Шилжүүлдэг	3375	85%	2869	2041	5.9	33%	48%	19%
Хүлээн авдаг		13%	439	3072	1.3	37%	51%	12%

¹⁰Чехийн гадаад иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газрын бүртгэл, 2012 оны 11 сарын байдлаар.

¹¹Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогоос жинлэн гаргасан дүн.

Судалгаагаар БНЧУ-д оршин сууж буй иргэд эх орон руугаа 2012 онд нийт 5.9 сая ам.долларын мөнгөн гуйвуулгыг хийж, 1.3 сая ам.долларын гуйвуулгыг хүлээн авсан дүн гарлаа. Шилжүүлж буй мөнгөн гуйвуулгын хувьд 1.9 сая ам.долларыг албан сувгаар буюу банкны гуйвуулгын үйлчилгээ, MoneyGram, Western Union зэрэг үйлчилгээг хэрэглэн шилжүүлсэн бол 2.8 сая ам.долларыг хувь хүнээр дамжуулан, үлдсэн 19% буюу 1.2 сая ам.долларыг ББСБ¹²-аар дамжуулж шилжүүлсэн байна. СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэйгөөр гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг ББСБ нь улсын хэмжээнд цөөн тоотой байдаг ба зөвшөөрөлгүйгээр гуйвуулгын үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд нь гуйвуулгыг янз бүрийн хэлбэрээр (бусад орны банкаар дамжуулах, хувь хүнээр дамжуулах гэх мэт) үйлддэг тул тусад нь авч үзлээ.

Хүснэгт 5: БНЧУ-д хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эх орон руугаа шилжүүлдэг 1 сарын дундаж дүн

Шилжүүлгийн хэмжээ (\$)	2005	2008	2011	2012
50-100	42%	0%	13%	13%
101-200	30%	38%	19%	26%
201-350	2%	23%	17%	17%
351-500	2%	14%	13%	4%
501-700	1%	7%	5%	1%
701-900	-	2%	2%	1%
901-ээс дээш	-	2%	3%	1%
Бараг шилжүүлдэггүй ¹³	23%	14%	28%	35%
Тодорхойгүй	-	-	-	2%

БНЧУ-д оршин сууж буй иргэдийн эх орон руугаа хийж буй гуйвуулгын өсөлт, хандлагыг шинжих зорилгоор энэ удаагийн судалгааны дүнг Монголын хүн ам, хөгжил нийгэмлэгийн судлаачдын багийн 2005 онд хийсэн “Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар” судалгааны дүн болон “Чех Улс дахь Монголчуудын Холбоо” ТББ ба “Mongolian Real Estate Management” ХХК-ны 2008 болон 2011 онд хамтран хийсэн

судалгааны дүнтэй харьцуулан Хүснэгт 6-д тусгалаа. Хүснэгтээс үзэхэд БНЧУ-д суугаа Монгол иргэдийн гуйвуулгын хэмжээ болон хандлага нь сүүлийн жилүүдэд буурч байгаа нь тодорхой харагдаж байна. Энэ нь (i) эдийн засгийн шилжилтийн үед хөдөлмөр эрхлэхээр гадагш явсан иргэд тэндээ тогтвор суурьшилтай амьдрах болсон, (ii) дотоодын инфляцийн түвшин зэргээс шалтгаалан эх орон руугаа гуйвуулга хийснээс гадаадаа хөрөнгө оруулалт хийсэн нь ашигтай болсон зэргээс шалтгаалж байж болох юм.

“Чехэд оршин суух эрх авсан иргэд хүүхдүүдээ татаж авдаг. Энэ нь Монгол руу шилжүүлэх хэмжээ багассантай бас холбоотой.”

/Чехэд оршин суугч иргэн/

VI. Үр дүн

Түүвэр судалгаанд хамрагдагсад нь эх олонлогийг бүрэн төлөөлнө гэсэн таамаглалд үндэслэвэл энэ удаагийн түүвэр судалгаагаар дараах үр дүнгүүд гарлаа.

- БНЧУ-д оршин сууж буй Монгол иргэдийн **85%** нь тодорхой давтамжтайгаар эх орон руугаа мөнгөн гуйвуулга хийдэг бөгөөд 2012 оны байдлаар ойролцоогоор **5.9 сая**

¹² Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгөөр мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг банк бус санхүүгийн байгууллага нь 2012 оны сүүлийн байдлаар 4 байгаа бөгөөд үүнээс “Шинэ төгрөг” болон “Мөнгөн гүүр”-ээр дамжуулан хийгддэг гүйлгээ нь гадаад гүйлгээний тайланд албан ёсоор тусгагддаг. Бусад ББСБ-уудын хувьд (зөвшөөрөлгүйгээр үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудыг хамруулан) дотоодын арилжааны банкуудаар дамжуулан шилжүүлэг хийсэн тохиолдолд тайланд тусгагдах ба гадаадын банкаар дамжуулан, эсвэл бусад аргаар шилжүүлсэн тохиолдолд тайланд тусгагддаггүй.

¹³ Сарын шилжүүлгийн дундаж дүн 50 ам.доллараас доош

ам.доллартай тэнцэх хэмжээний гадаад валютыг гуйвуулсан байна. Гуйвуулсан зорилгоор авч үзвэл 50% нь ар гэрийнхээ хувийн хэрэгцээнд, 20% нь зээл төлөх, 11% нь банкин хадгалуулах, 17% нь бизнесийн хөрөнгө оруулалт хийх, орон сууц худалдан авах зорилгоор тус тус шилжүүлсэн байна.

- Монгол иргэдийн **13%** нь бараа, бүтээгдэхүүн худалдан авч Монгол явуулах зорилгоор 2012 оны байдлаар гэрээсээ **1.3 сая** ам.долларыг хүлээж авсан байна.
- Нийт гуйвуулгын тал орчим хувь нь албан бус сувгаар буюу хувь хүнээр голчлон дамжуулагдан үйлдэгдэж байна. Энэ удаагийн судалгааны дүнг Төлбөрийн тэнцэлд тусгавал ургал шилжүүлгийн дансны орлого 2012 оны байдлаар **2.1 сая** ам.доллараар нэмэгдэхээр байна.
- Сүүлийн жилүүдэд БНЧУ-д хөдөлмөр эрхэлж буй иргэдийн эх орон руугаа гуйвуулах мөнгөний хэмжээ, давтамж буурсан үзүүлэлтэй байгаа бөгөөд энэ нь (i) эдийн засгийн шилжилтийн үед хөдөлмөр эрхлэхээр гадагш явсан иргэд тухайн улсдаа тогтвор суурьшилтай амьдрах болсон, (ii) дотоодын инфляцийн түвшин зэргээс шалтгаалан эх орон руугаа гуйвуулга хийснээс гадаадад хөрөнгө оруулалт хийх нь илүү ашигтай болсон зэргээс шалтгаалсан байж магадгүй байна.

--- оОо ---

Ашигласан материал

- Монгол Улсын Төлбөрийн тэнцэл, 2000-2012 оны тоон өгөгдлүүд
- Банкуудын гадаад гүйлгээний тайлан, 2008-2012 оны тоон өгөгдлүүд
- Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадад зорчсон Монгол иргэдийн судалгаа, 2000-2012 оны тоон өгөгдлүүд
- Монгол Улсын Төлбөрийн тэнцлийг боловсруулах аргачлал (3 дахь өөрчлөлт)
- Санхүүгийн зохицуулах хороо, Тусгай зөвшөөрөлтэйгөөр үйл ажиллагаа эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагуудын дэлгэрэнгүй судалгаа, 2012
- Монгол Улсын үндэсний статистикийн хороо, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллого, 2010
- Монголын хүн ам, хөгжил нийгэмлэг, “Монгол иргэдийн гадаадад хөдөлмөр эрхлэлтийн байдал, үр дагавар” судалгааны тайлан, 2005
- Чех Улс дахь Монголчуудын Холбоо болон “Mongolian real estate management” ХХК-ын хамтарсан судалгаа, БНЧУ дахь Монголчуудаас авсан санал асуулгын үр дүнгүүд, 2008, 2011



МОНГОЛБАНК

ЧЕХ УЛС ДАХЬ
МОНГОЛЧУУДЫН ХОЛБОО

БНЧУ-Д АЖИЛЛАЖ, АМЬДАРЧ БУЙ МОНГОЛ ИРГЭДИЙН МӨНГӨН ГУЙВУУЛГЫН ХЭМЖЭЭГ ТООЦООЛОХ ТҮҮВЭР СУДАЛГАА

Гадаад орнуудад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдийн эх орон руугаа илгээж байгаа мөнгөн гуйвуулгын хэмжээ жилээс жилд нэмэгдэн, улс орны эдийн засагт үнэтэй хувь нэмэр оруулсаар ирсэн билээ. Иймд энэ үзүүлэлтийн статистик мэдээний чанарыг сайжруулах, бодлогын санал боловсруулах зорилгоор Монголбанк болон “Чех Улс дахь Монголчуудын Холбоо” ТББ-аас хамтран хийж байгаа энэхүү судалгаанд Таныг идэвхтэй оролцож, бидний ажилд гүн тусалцаа үзүүлнэ гэдэгт итгэж байна.

1. **БНЧУ-д улсад оршин сууж буй зорилго?**/Давхар сонголт хийж болно./
 - a. Суралцах
 - b. Ажиллах
 - c. Тогтвор суурьшилтай амьдрах
2. **Оршин сууж буй хугацаа?**
 - a. 0-1 жил
 - b. 1-3 жил
 - c. 3-5 жил
 - d. 5-аас дээш жил
3. **Таны 1 сарын орлого дунджаар хэд вэ?** /Кč-аарилэрхийлсэндүнгээроруулнауу./
4. **Та орлогоосоо хуримтлал үүсгэдэг үү?**
 - a. Тийм
 - b. Үгүй
5. **Хуримтлалүүсгэдэгболхуримтлалтаньойрын 1 жилийнхугацаандөссөнүү?**
 - a. Тийм
 - b. Үгүй
6. **Та гэр рүүгээ мөнгө шилжүүлдэг, эсхүл гэрээсээ мөнгө хүлээн авдаг уу?**/2 сонголтхийжболно/
 - a. Шилжүүлдэг. (5-7-р асуултанд хариулна уу.)
 - b. Хүлээн авдаг. (8, 9-р асуултанд хариулна уу.)
 - c. Үгүй
7. **Хэрэв шилжүүлдэг бол нэг удаад хэдий хэмжээний мөнгө шилжүүлдэг вэ?** /Ам.доллараарилэрхийлсэндүнгээроруулнауу/
8. **Та ямар давтамжтайгаар шилжүүлдэг вэ?**
 - a. Жилд 1-2 удаа
 - b. Улиралд 1-2 удаа
 - c. Сард 1-2 удаа
 - d. Бусад

9. **Танаас хүлээж авсан гуйвуулгыг юунд зарцуулдаг вэ?** /Нэг жилийн хугацаанд хүлээн авах нийт гуйвуулгын хэдэн хувийг тухайн зорилгоор зарцуулдаг болохыг ард нь бөглөнө үү./
- | | |
|--|---------|
| a. Хувийн хэрэглээнд | /...../ |
| b. Орон сууц, үл хөдлөх хөрөнгө авахад | /...../ |
| c. Бизнесийн хөрөнгө оруулалт хийхэд | /...../ |
| d. Зээл төлөхөд | /...../ |
| e. Банкинд хадгалуулахад | /...../ |
| f. Бусад | /...../ |
10. **Хэрэв хүлээн авдаг бол нэг удаад хэдий хэмжээний мөнгө хүлээн авдаг вэ?**
/Ам.доллараарилэрхийлсэндүнгээроруулнауу. /
-
11. **Та ямар давтамжтайгаар хүлээн авдаг бэ?**
- | | |
|---------------------|------------------|
| a. Жилд 1-2 удаа | c. Сард 1-2 удаа |
| b. Улиралд 1-2 удаа | d. Бусад |
12. **Мөнгийг ихэвчлэн ямар хэлбэрээр шилжүүлдэг вэ?** /Давхар сонголт хийж болно./
- | |
|---|
| a. Банкны гуйвуулгын үйлчилгээ (SWIFT, Eurogiris гэх мэт) |
| b. Western Union |
| c. MoneyGram |
| d. Хувь хүнээр дамжуулан |
| e. Олонулсынкарт (Visa, Master гэхмэт) |
| f. Гадаад гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг банк бус санхүүгийн байгууллага |
| g. Бусад |
13. **Дээрх хэлбэрээр мөнгө гуйвуулдаг гол шалтгаан тань юу вэ?**
- | | |
|-----------------------------------|-------------------|
| a. Найдвартай байдал, эрсдэл бага | b. Хурдан шуурхай |
| c. Шимтгэл хямд | d. Бусад |
14. **Таны бодлоор хувийн гуйвуулгын талаар ямар арга хэмжээ авах шаардлагатай вэ?**
/Давхар сонголт хийж болно./
- | | |
|--|-----------------------|
| a. Шимтгэлийг бууруулах | b. Эрсдлийг бууруулах |
| c. Шилжүүлгийг хурдан болгох | d. Бусад..... |
| e. Жижиг хотуудаас бага хүүтэй мөнгө шилжүүлэх боломж гаргах | |
15. **Бусад санал, хүсэлт байвал хуваалцана уу.**
.....
16. **Таны боловсролын түвшин**
- | | |
|---------------|------------|
| a. Бүрэн дунд | c. Магистр |
| b. Бакалавр | d. Доктор |
17. **Таны нас**
- | | |
|----------|----------------|
| a. 18-25 | c. 30-45 |
| b. 25-30 | d. 45-аас дээш |
18. **Таны хүйс**
- | | |
|------------|------------|
| a. Эрэгтэй | b. Эмэгтэй |
|------------|------------|

Судалгаанд идэвхтэй оролцсон танд баярлалаа

Гадаадад оршин суугаа Монгол улсын иргэдийн тоо, бүтэц

Оршинсуугааулс	Хүнийтоо	Явсанзорилго			
		Суралцах	Хөдөлмөрийнг эрээгээражилл ах	Хувиараа ажиллах	Бусад
ӨмнөдСолонгос	29534	22%	40%	22%	16%
Америк	17036	44%	4%	20%	33%
Чех	7274	9%	52%	19%	21%
Хятад	7273	71%	4%	8%	17%
Япон	5401	48%	11%	14%	27%
Орос	5008	67%	3%	10%	19%
Герман	3852	48%	4%	13%	35%
Англи	3701	55%	4%	17%	24%
Франц	2859	18%	9%	30%	43%
Турк	2645	54%	8%	30%	8%
Казакстан	2523	57%	6%	20%	18%
Унгар	1615	15%	39%	20%	26%
Бусад	18419	36%	8%	23%	33%
Нийт	107140	37%	19%	20%	24%

Эх сурвалж: ҮСХ, Хүн ам, орон сууцны 2010 оны улсын тооллогын нэгдсэн дүн